

**ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**НЭГ.ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ БОЛСОН
ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА**

Цагдаагийн албаны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна.

1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:” гээд 13-д “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. ...” гэж, Арван есдүгээр зүйлийн 1-д 1.Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж тус тус хуульчилсан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.1.14-д “Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцод нийцүүлэх...”, 4.2.3.11-д “Хууль сахиулагчдын мэргэшил, нийгэм, эдийн засгийн баталгааг сайжруулж, хууль сахиулагч болон хууль сахиулах албаны эрх зүйн байдлыг тодорхойлсон хууль, эрх зүйн орчныг бий болгоно.”, 4.2.3.8-д “Төрийн албаны сургалтын байгууллагын хөтөлбөрийг төрийн албаны шинэчлэлд нийцүүлж, сургалтын байгууллагын чадавхыг бэхжүүлнэ.” гэж тус тус заасан.

1.2.Практик шаардлага

Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага үүссэнийг илтгэх хэд хэдэн практик шаардлага үүссэн байна. Үүнд:

1. Монгол Улсад 5 жилийн дараа буюу 2024 онд гэмт хэрэг 41.515 буюу 14.6 хувь, гэмт хэргийн улмаас нас барсан хүний тоо 1.135 буюу 21.5 хувь, хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 30.0 хувь, бусдын бие махбодод гэмтэл учруулах хэрэг 15.0 хувиар, жагсаал, цуглааны хэтийн төлөвийг шугаман хамаарлын тооцооллоор тооцож үзэхэд жагсаал, цуглаан 2024 онд 235, 2025 онд 250, 2026 онд 264, 2028 онд 293 болж тус тус өсөх хандлагатай гэсэн дүн шинжилгээ гарсан байна.¹

¹ Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албанаас гаргасан мэдээлэл 2024 он

Мөн үндэсний аюулгүй байдал, ард түмний эв нэгдэлд хохирол учруулахуйц эмх замбараагүй байдлыг дэвэргэх гэсэн сонирхол бүхий этгээдүүдэд хуулийн байгууллагын үйл ажиллагаанд хөндрөнгөөс нөлөөлөх, улс төржүүлэх, хууль сахиулагчдын нийтийн эрх ашгийн төлөө тавьсан шаардлагыг эсэргүүцэх, хууль зөрчих зэрэг үйлдэл гарах болсон.

Цагдаагийн байгууллагын дотоод хяналт шалгалтаар сүүлийн 5 жилд шалгагдсан алба хаагчдын 67.7 хувь нь буруутай болох нь тогтоогдоогүй нөхцөл байдлаас шалтгаалан алба хаагчийн үүрэг гүйцэтгэх үед энгэрийн камер, тээврийн хэрэгсэлд байх камерыг нэмэгдүүлэх, байнга ашиглах зайлшгүй хэрэгцээ, шаардлага үүссэн байна.

2.Улс орнуудын цагдаагийн байгууллагын нийтлэг зорилго нь нийгмийн аюулгүй, амар тайван байдлыг хамгаалах, түүнд үйлчлэх явдал юм. Гэсэн хэдий ч үйл ажиллагаа явуулах арга барил нь тодорхой шалтгааны улмаас өөр байж болно. Цагдаагийн алба хаагчийн сургалт нь цагдаагийн байгууллагын чиг үүрэг хэрхэн хэрэгжихийг тодорхойлох гол хүчин зүйлүүдийн нэг юм.

Монгол Улсад цагдаагийн алба хаагчийг сургах боловсрол, сургалтын тогтолцоог онцгой анхаарч Засгийн газраас үе шаттайгаар, тасралтгүй хөгжүүлэхээр бодлогын баримт бичгүүдэд тусгаж ирсэн ч хэрэгжилт хангалтгүй, сургалтын нэгдсэн тогтолцоог оновчтой тодорхойлоогүй байна.

3.Монгол Улсын иргэн халдашгүй, чөлөөтэй байх, хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хуулиар хориглосон бөгөөд албадан зогсоох, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах ажиллагаа нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны А/101 дугаартай тушаалаар баталсан “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах журам”-аар зохицуулагдаж байна.

4.Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтад Төрийн албанд мэргэшсэн тогтвортой байх зарчмыг баримтлахаар заасныг хэрэгжүүлэх, түүнчлэн Тагнуулын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Тагнуулын ерөнхий газрын даргаар төрийн албанд 15-аас доошгүй жил ажилласан, сүүлийн 5 жил төрийн албанд тасралтгүй ажиллаж байгаа Монгол Улсын иргэнийг Ерөнхий сайд Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцэн санал болгосноор Засгийн газар 6 жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө.”, Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт “Авлигатай тэмцэх газрын даргыг Ерөнхий сайдын санал болгосноор Улсын Их Хурал томилгооны сонсгол хийж 6 жилийн хугацаагаар томилно.” гэж тус тус зохицуулсантай адилтган төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг цагдаагийн байгууллагын удирдлагыг мөн тодорхой хугацаагаар томилдог, чөлөөлдөг зохицуулалтыг бий болгох, цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтныг тогтоосон хугацаанаас өмнө чөлөөлөх асуудлыг шийдвэрлэгдээгүй байна.

5.Гадаад харилцааны яамны Консулын газрын мэдээллээр 2024 оны эхний улирлын байдлаар Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс зэрэг дэлхийн 20 гаруй улсын цагдаа, хууль сахиулах байгууллагад Монгол Улсын 75 иргэн хууль бусаар оршин суух, танхайрах, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, хулгайллах, хүчиндэх, биеэ үнэлэх, хүний амь нас, эрүүл

мэндэд хохирол учруулах, залилан мэхлэх, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар олж авах, хадгалах, тээвэрлэх, нэвтрүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, журам зөрчих, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх зэрэг гэмт хэрэг, зөрчилд холбогдон саатууллагдан шалгагдаж байгаа төдийгүй 202 иргэн дээрх төрлийн гэмт хэрэгт шийтгэгдэн 3 сараас 25 жилийн хугацаатай хорих ял эдэлж байна.

Монгол Улсын хэмжээнд 2023 оны байдлаар хар тамхи, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэг 238, кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 388 бүртгэгдсэн нь өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд хилийн чанадад сурч, ажиллаж, амьдарч, дамжин өнгөрч буй Монгол Улсын иргэдийн эрх ашгийг хамгаалах, гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоо чиглэлээр гадаад улсын цагдаа, хууль сахиулах байгууллагатай мэдээ, мэдээлэл шуурхай солилцож, хамтран ажиллах үндсэн үүрэг бүхий цагдаагийн атташег томилон ажиллуулах зайлшгүй хэрэгцээ шаардлага үүссэн.

Иймд дээр дурдсан бодлогын баримт бичиг туссан зорилт болон цагдаагийн байгууллага хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрхийг ойлгох, хууль сахиулах ажлын ухагдахуун, ёс зүйг дээшлүүлэх бодлогыг хэрэгжүүлж энэ талын онолын болон практик сургалтыг үр дүнтэй зохион байгуулах, хүний эрхийг хөндөх хязгаарлалт, албадлага шаардсан арга хэмжээг зөвхөн хуулиар тогтоох, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хуульд тогтоомжоор хориглоогүй арга хэрэгслээр нийтэд мэдээ, мэдээлэл түгээх, гадаад улсад байгаа иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах хэрэгцээ, шаардлага үүссэн гэж үзэж байна.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛИЙН БҮТЭЦ, ЗОХИЦУУЛАХ ХАРИЛЦАА, ХАМРАХ ХҮРЭЭ

Цагдаагийн албаны тухай хууль 2017 онд батлагдсан, 10 бүлэг, 97 зүйлтэй бөгөөд Монгол Улсын цагдаагийн албаны тогтолцоо, үйл ажиллагаа, цагдаагийн алба хаагчийн эрх зүйн байдал, цагдаагийн байгууллагад тавих иргэний хяналтын эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулдаг.

Дээрх хуульд 3.1.7, 20.5, 20.6, 20.7, 20.8, 36.6, 36.4, 36.5, 36.6, 36.7, 36.8, 36.9, 36.10, 55.3, 55.4, 55.5, 55.6, 55.7, 59.5, 59.6, 69.1.13, 80.4 гэсэн хэсэг тус тус нэмэх, 20.1, 22.2, 23.3, 36, 89.1, 89.2, 93.2, 97.2 гэсэн хэсэгт тус тус нэмэлт оруулах, 17 дугаар зүйлийг өөрчлөн найруулах, 22.5, 22.7, 28.2.1, 30.3, 38.1 дэх хэсгийг тус тус өөрчлөх, 20.1.12, 80.1.1, 88.3 дахь хэсгийг тус тус хасаж хуулийг боловсронгуй болгоно.

ГУРАВ.ХУУЛИЙН ТӨСӨЛ БАТЛАГДСАНЫ ДАРАА ҮҮСЭЖ БОЛОХ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮР ДАГАВАР

Хуулийн төсөл батлагдсанаар дараах эерэг үр дагавар бий болно гэж үзэж байна;

-Цагдаагийн албаны сургалтын үйл ажиллагааг илүү нарийвчлан мэргэжлийн болон албаны давтан сургалтын үйл ажиллагааг боловсронгуй, орчин үеийн чиг хандлагад нийцүүлэх, байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд хүний эрхийг дээдэлсэн арга барил нэвтрэх;

-Алба хаагчийн явуулж байгаа үйл ажиллагааг дуу-дүрсний төхөөрөмжөөр баримтжуулах нь гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирсон болон холбогдсон, бусад хүний эрх, эрх чөлөөг болон тэдний аюулгүй байдлыг хамгаалах боломж нэмэгдэх;

-Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хуульд тогтоомжоор хориглоогүй арга хэрэгслээр нийтэд мэдээ, мэдээлэл түгээх боломжийг бүрдүүлэхснээр байгууллагын үйл ажиллагааг ил тод байдал нэмэгдэх боломжтой болно;

-Хилийн чанадад сурч, ажиллаж, амьдарч, дамжин өнгөрч буй Монгол Улсын иргэдийг гэмт хэрэг, зөрчилд холбогдох, өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, таслан зогсоох чиглэлээр гадаад улсын цагдаа, хууль сахиулах байгууллагатай мэдээ, мэдээлэл шуурхай солилцож, хамтран ажилласнаар иргэдийн эрх ашиг хамгаалагдана;

-Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын иргэн халдашгүй чөлөөтэй байх эрхтэй бөгөөд хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч баривчлахыг хориглосон тул журмаар зохицуулагдаж байгаа замын хөдөлгөөн зохицуулах, тээврийн хэрэгслийг албадан зогсоох зохицуулалтыг тус хуульд тусгаснаар хүний эрх, эрх чөлөөг хангагдах нөхцөл бүрдэнэ.

Хуулийн төсөл батлагдсанаар төсвөөс нэмэлт санхүүжилт шаардагдахгүй, цагдаагийн байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар:

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлтэй холбогдуулан Дипломат албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Дотоотын цэргийн тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг тус тус дагалдуулан боловсруулна.

---оОо---